



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/200

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1, 18.2.3, 2023 оныг “Монголд зочлох жил”-ээр зарлах тухай Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдааны 20 дугаар тэмдэглэл, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 12 дугаар хуралдааны 14 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2023 оныг “Монголд зочлох жил”, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас “Хөвсгөлд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан тус арга хэмжээг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Хөвсгөл аймагт зочлох жилийн хүрээнд зохион байгуулагдах ажлын төлөвлөгөөг боловсруулж, холбогдох төсвийн тооцоог боловсруулан 2022 оны 06 дугаар сарын 25-ны дотор танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч, аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (П.Ариунбат)-д даалгасугай.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2022 оны 06  
дугаар сарын 13-ны өдрийн А/...  
дугаар захирамжийн хавсралт



Ажлын хэсгийн ахлагч:

- П.Ариунбат (Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
- Гишүүд:
- П.Мөнхжаргал (Аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
- Ж.Даваадамдин (Аймгийн Соёл, урлагийн газрын дарга)
- Х.Рагчаа (Орон нутаг судлах музейн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
- Б.Банзрагч (Аймгийн Хөгжимт драмын театрын дарга)
- Л.Даваабаяр (Ханх сумын Засаг дарга)
- А.Баттүшиг (Хатгал тосгоны захирагч)
- Б.Ганхөлөг (Гар урчуудын холбооны тэргүүн)
- Ж.Сарангэрэл (Аймаг дахь Худалдаа аж үйлдвэрийн танхимын дарга)
- М.Сарангэрэл ("Тайгын цаа травэл тур" оператор компанийн захирал)
- П.Эрдэнэ-Уул (Аялал жуулчлал, зочлох үйлчлээний холбооны тэргүүн)
- Н.Цэнддаваа (Хатгал тосгоны гэр буудлын холбооны тэргүүн "Монгол үжин" жуулчны баазын захирал)
- Я.Отгонбаяр (Хөвсгөлийн аялал жуулчлал эрхлэгчдийн холбооны тэргүүн)
- Д.Оргилбаатар (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн)
- Нарийн бичгийн дарга:
- Ё.Батсайхан (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Байгаль орчин, уул уурхай, аялал жуулчлалын бодлого хариуцсан мэргэжилтэн)

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_